

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/215/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Хөвсгөл аймаг
2022 он

Хөвсгөл аймаг дахь Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ
Утас: 99900662 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn
Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг
Утас: 99016320 Цахим хаяг: erdenechimegg@audit.gov.mn
Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн
Захирал: Ахлах аудитор Б.Мядагмаа
Утас: 99389208 Цахим хаяг: ikhermurun.audit@gmail.com
Чанарын хяналтын менежер: Ц.Мөнхтуяа
Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4-10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт.....	14-15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/150
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН МӨРӨН СУМЫН
ДОЛООДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Д.УНДАРМАА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Долоодугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Долоодугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>108,419,889.07</u>	<u>110,612,731.13</u>
33	АВЛАГА	1,420,450.00	1,420,450.00
335	Бусад авлага	1,420,450.00	1,420,450.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,420,450.00	1,420,450.00
35	БАРАА МАТЕРИАЛ	106,999,439.07	109,192,281.13
351	Түүхий эд материал	2,986,900.00	3,132,983.70
35130	Эм боох материал	2,986,900.00	3,132,983.70
354	Хангамжийн материал	104,012,539.07	106,059,297.43
35410	Бичиг хэргийн материал	717,500.00	660,500.00
35420	Аж ахуйн материал	997,400.00	758,999.99
35460	Хүнсний материал	3,813,984.28	5,112,042.48
35470	Бусад хангамжийн материал	98,483,654.79	99,527,754.96
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>704,761,268.25</u>	<u>720,664,103.99</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	704,761,268.25	720,664,103.99
392	Биет хөрөнгө	441,413,768.25	441,966,603.99
39201	Барилга, байгууламж, орон сууц	450,769,000.00	450,769,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-69,609,716.27	-98,442,550.55
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	58,049,189.87	69,654,968.54
39206	Хуримтлагдсан элэгдэл	-32,573,293.35	-13,239,727.07
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,196,808.63	15,547,839.63
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,099,398.17	-7,236,107.94
39214	Бусад үндсэн хөрөнгө	50,386,920.00	50,386,920.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-21,138,242.46	-27,906,238.62
39217	Ном	2,432,500.00	2,432,500.00
393	Биет бус хөрөнгө	263,347,500.00	278,697,500.00
39301	Програм хангамж	787,000.00	787,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-787,000.00	-787,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	263,347,500.00	278,697,500.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>813,181,157.32</u>	<u>831,276,835.12</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>413,917.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	413,917.00	00.00
413	Өглөг	413,917.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	413,917.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>812,767,240.32</u>	<u>831,276,835.12</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	812,767,240.32	831,276,835.12
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	530,069,997.49	545,419,997.49
51101	Өмч: - төрийн	530,069,997.49	530,069,997.49
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	00.00	15,350,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	-148,965,272.74	-145,545,339.94
51210	Өмнөх үеийн үр дүн	-148,965,272.74	-148,704,934.74
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	3,159,594.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	431,662,515.57	431,402,177.57
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>813,181,157.32</u>	<u>831,276,835.12</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	720,135,740.00	737,000,166.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	719,820,740.00	22,870,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	14,711,540.00	22,870,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,711,540.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	14,711,540.00	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө	00.00	13960200.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-бараа материал	00.00	8910300.00
122	Тусламжийн орлого	86,508,600.00	00.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	618,600,600.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	618,600,600.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	315,000.00	714,129,666.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	617,390,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	617,390,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	315,000.00	2,686,066.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	2,371,066.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	315,000.00	315,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	94,053,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	94,053,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	701,532,390.29	726,533,671.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	701,532,390.29	726,533,671.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	672,922,538.23	716,657,551.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	428,685,429.32	462,158,090.94
210101	Үндсэн цалин	354,653,335.58	305,615,028.91
210102	Нэмэгдэл	44,495,793.90	112,568,731.03
210104	Урамшуулал	29,536,299.84	43,974,331.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,239,900.00	59,714,785.14
210201	Тэтгэврийн даатгал	39,785,500.00	41,338,026.27
210202	Тэтгэмжийн даатгал	4,363,600.00	4,594,169.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,490,900.00	3,675,355.12
210204	Ажилгүйдлийн даатгал	872,700.00	918,810.65
210205	Эрүүл мэндийн даатгал	8,727,200.00	9,188,423.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84,571,800.00	85,777,726.51
210301	Гэрэл, цахилгаан	1,955,313.15	3,026,046.32
210302	Түлш, халаалт	74,727,488.85	76,637,202.08
210303	Цэвэр, бохир ус	7,888,998.00	6,114,478.11
2104	Хангамж, бараа материалын зардал	15,018,015.82	19,535,865.84
210401	Бичиг хэрэг	1,928,500.00	439,100.00
210402	Тээвэр, шатахуун	550,000.00	220,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	492,610.00	1,222,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,614,990.00	3,061,566.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,525,352.02	8,644,100.01
210408	Бараа материал акталсны зардал	4,906,563.80	5,948,399.83
2105	Нормативт зардал	30,711,944.16	29,836,419.10

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	865,500.00	6,785,016.30
210502	Хоол, хүнс	29,846,444.16	23,051,402.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,636,500.00	6,733,400.00
210604	Урсгал засвар	3,636,500.00	6,733,400.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	96,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	96,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,596,600.00	1,919,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,246,600.00	1,199,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	720,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,462,348.93	50,886,264.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,552,366.90	582,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,030,600.00	6,406,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	40,879,382.03	43,897,364.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,609,852.06	9,876,119.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	300.00	1,258,873.49
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	300.00	1,258,873.49
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,809,552.06	8,617,245.92
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,809,552.06	8,617,245.92
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	18,603,349.71	10,466,494.80
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	7,306,900.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	7,306,900.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-7,306,900.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	18,603,349.71	3,159,594.80

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн /төгрөгөөр/
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	266,722,497.49	106,417,723.52	-108,514,498.03	264,625,722.98
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	266,722,497.49	106,417,723.52	-108,514,498.03	264,625,722.98
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-13,053,238.65	-13,053,238.65
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	530,069,997.49	431,662,515.57	-148,965,272.74	812,767,240.32
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	530,069,997.49	431,662,515.57	-148,965,272.74	812,767,240.32
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	260,338.00	260,338.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	530,069,997.49	431,662,515.57	-148,704,934.74	813,027,578.32
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-260,338.00	00.00	-260,338.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	15,350,000.00	00.00	00.00	15,350,000.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	3,159,594.80	3,159,594.80

D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	545,419,997.49	431,402,177.57	-145,545,339.94	831,276,835.12
-----	---------------------------------------	----------------	----------------	-----------------	----------------

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	705,424,200.00	714,129,666.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	705,109,200.00	00.00
122	Тусламжийн орлого	86,508,600.00	00.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	618,600,600.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	618,600,600.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	315,000.00	714,129,666.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	617,390,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	617,390,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	315,000.00	2,686,066.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	2,371,066.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	315,000.00	315,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	94,053,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	94,053,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	695,051,200.00	683,639,666.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	695,051,200.00	683,639,666.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	666,441,347.94	673,763,546.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	428,685,429.32	460,264,868.94
210101	Үндсэн цалин	354,653,335.58	305,615,028.91
210102	Нэмэгдэл	44,495,793.90	112,568,731.03
210104	Урамшуулал	29,536,299.84	42,081,109.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,239,900.00	62,021,924.14
210201	Тэтгэврийн даатгал	39,785,500.00	43,645,165.24
210202	Тэтгэмжийн даатгал	4,363,600.00	4,594,169.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,490,900.00	3,675,355.15
210204	Ажилгүйдлийн даатгал	872,700.00	918,810.65
210205	Эрүүл мэндийн даатгал	8,727,200.00	9,188,423.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	82,871,800.00	85,657,726.51
210301	Гэрэл, цахилгаан	1,955,313.15	3,026,046.32
210302	Түлш, халаалт	73,027,488.85	76,517,202.08
210303	Цэвэр, бохир ус	7,888,998.00	6,114,478.11
2104	Хангамж, бараа материалын зардал	24,323,100.00	18,800,766.00
210401	Бичиг хэрэг	1,928,500.00	689,700.00
210402	Тээвэр, шатахуун	550,000.00	340,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	492,610.00	1,222,700.00
210404	Ном, хэвлэл	415,400.00	353,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,977,990.00	3,241,566.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,958,600.00	12,952,900.00
2105	Нормативт зардал	44,952,918.62	29,400,561.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,466,200.00	3,635,500.00
210502	Хоол, хүнс	23,865,118.62	24,349,461.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	17,621,600.00	1,415,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,063,500.00	8,296,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,167,000.00	1,160,000.00

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210602	Тавилга	3,260,000.00	00.00
210604	Урсгал засвар	3,636,500.00	7,136,400.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	96,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	96,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,996,600.00	1,919,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,246,600.00	1,199,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	750,000.00	720,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,308,100.00	7,306,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	582,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,308,100.00	6,724,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,609,852.06	9,876,119.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	300.00	1,258,873.49
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	300.00	1,258,873.49
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,809,552.06	8,617,245.92
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,809,552.06	8,617,245.92
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	10,373,000.00	30,490,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,373,000.00	30,490,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,373,000.00	30,490,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,373,000.00	30,490,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,373,000.00	30,490,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-10,373,000.00	-30,490,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	711,443,600.00	701,567,480.59	9,876,119.41	98.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	711,443,600.00	701,567,480.59	9,876,119.41	98.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	711,443,600.00	701,567,480.59	9,876,119.41	98.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	460,266,200.00	460,264,868.94	1,331.06	100.00
210101	Үндсэн цалин	308,602,800.00	305,615,028.91	2,987,771.09	99.03
210102	Нэмэгдэл	115,375,700.00	112,568,731.03	2,806,968.97	97.57
210104	Урамшуулал	36,287,700.00	42,081,109.00	-5,793,409.00	115.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,135,800.00	62,021,924.14	113,875.86	99.82
210201	Тэтгэврийн даатгал	43,725,300.00	43,645,165.24	80,134.76	99.82
210202	Тэтгэмжийн даатгал	4,602,600.00	4,594,169.14	8,430.86	99.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,682,100.00	3,675,355.15	6,744.85	99.82

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	920,500.00	918,810.65	1,689.35	99.82
210205	Эрүүл мэндийн даатгал	9,205,300.00	9,188,423.96	16,876.04	99.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	86,916,600.00	85,657,726.51	1,258,873.49	98.55
210301	Гэрэл, цахилгаан	3,500,000.00	3,026,046.32	473,953.68	86.46
210302	Түлш, халаалт	76,616,600.00	76,517,202.08	99,397.92	99.87
210303	Цэвэр, бохир ус	6,800,000.00	6,114,478.11	685,521.89	89.92
2104	Хангамж, бараа материалын зардал	16,756,200.00	16,746,700.00	9,500.00	99.94
210401	Бичиг хэрэг	424,700.00	424,700.00	00.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	300,000.00	300,000.00	00.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,224,700.00	1,222,700.00	2,000.00	99.84
210404	Ном, хэвлэл	353,900.00	353,900.00	00.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,000.00	2,492,500.00	7,500.00	99.70
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,952,900.00	11,952,900.00	00.00	100.00
2105	Нормативт зардал	37,575,600.00	29,400,561.00	8,175,039.00	78.24
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,641,600.00	3,635,500.00	6,100.00	99.83
210502	Хоол, хүнс	32,518,400.00	24,349,461.00	8,168,939.00	74.88
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,415,600.00	1,415,600.00	00.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,786,400.00	38,786,400.00	00.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	28,650,000.00	28,650,000.00	00.00	100.00
210602	Тавилга	3,000,000.00	3,000,000.00	00.00	100.00
210604	Урсгал засвар	7,136,400.00	7,136,400.00	00.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	96,000.00	96,000.00	00.00	100.00
210702	Дотоод албан томилолт	96,000.00	96,000.00	00.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,186,500.00	1,869,000.00	317,500.00	85.48
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,466,500.00	1,149,000.00	317,500.00	78.35
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00	00.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6724300.00	6724300.00	00.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,724,300.00	6,724,300.00	00.00	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	711,443,600.00	701,567,480.59	9,876,119.41	98.61
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	617,390,600.00	608,773,354.08	8,617,245.92	98.60
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	617,390,600.00	608,773,354.08	8,617,245.92	98.60
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	94,053,000.00	92,794,126.51	1,258,873.49	98.66
132001	Орон нутгийн төсвөөс	94,053,000.00	92,794,126.51	1,258,873.49	98.66
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	40.00	40.00	00.00	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00	00.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	21.00	21.00	00.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,686,066.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,686,066.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,686,066.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,054,066.00
210401	Бичиг хэрэг	265,000.00
210402	Тээвэр, шатахуун	40,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	749,066.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	50,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	582,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	582,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,686,066.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,686,066.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,371,066.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	315,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримтын бүрдэл, шилэн дансны мэдээлэлтэй холбоотой зөвлөмж өгөгдсөн болно.

Аудитыг Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал, ахлах аудитор Б.Мядагмаа, аудиторын туслах Ж.Уранчмэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Ц.Мөнхтуяа хэрэгжүүлж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ нар анхан шатанд, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хоёр дахь шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 7 дугаар хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 06 дугаар албан бичгээр Ихэрмөрөн-Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 7 дугаар цэцэрлэг нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагаа явуулж байна.

2021 онд багш, сурагч, эцэг эхийн хамтын ажиллагаанд тулгуурласан хосолсон сургалтын хэлбэрийг нэвтрүүлэн, хичээл, сургалтын үйл ажиллагаанд бие даан суралцах арга зүйг хэрэгжүүлж, хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг дэмжин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд: Нийгмийн даатгалын тухай хуульд заасан шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт орж, Монгол Улсын засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 43-р тогтоол, “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг шинэчлэх тухай” Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал батлагдаж гарсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторроос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Бага" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 701.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 14.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 11.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан загвараар бэлтгэсэн байна.

2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 831.3 сая төгрөгөөр буюу 2.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00	00	00
Авлага	1.4	1,4	00
Урьдчилгаа	00	00	00
Бараа материал	107.0	109.2	2.2
Үндсэн хөрөнгө	704.7	720.7	16.0
Нийт хөрөнгө	813.2	831.3	18.1
Өр төлбөр	0.4	0	0.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	812.7	831.3	18.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	813.2	831.3	18.1

Бараа материалын дансны үлдэгдэл 109.2 сая төгрөг болж 2.2 сая төгрөгөөр буюу 2 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 720.7 сая төгрөг болж 16.0 сая төгрөгөөр буюу 2.7 хувиар өссөн байгаа нь дараах ажил гүйлгээ нөлөөлсөн байна. Үүнд:

- Батлагдсан төсвөөс 10.7 сая төгрөгийн сургалтын хэрэглэгдэхүүн болох тавилга тоног төхөөрөмж, Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчид хүсэлт гаргаж шийдүүлж 19.8 сая төгрөгийн компьютер, принтер, болон бусад сургалтын хэрэглэгдэхүүний тоног төхөөрөмж авсан байна.
- Боловсролын яамнаас 6.0 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж үнэ төлбөргүй нийлүүлэгдсэн :
- Хөвсгөл аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор Үндсэн хөрөнгө худалдах, актлах, шилжүүлэх тухай шийдвэрээр ашиглалтын хугацаа дууссан цаашид ашиглах боломжгүй 3 нэр төрлийн 9.8 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна.
- Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 11 дугаар сарын 29-ны өдрийн 39 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглалтын шаардлага хангахгүй 6 нэр төрлийн 3.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан. Мөн анхны өртгөө нөхөж, “0 үлдэгдэлтэй болсон боловч ашиглагдаж байгаа 16.1 сая төгрөгийн анхны өртөг бүхий 23 нэр төрөл бүхий үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг нэмэгдүүлэн 7.6 сая төгрөгөөр өртгийг шинэчлэн тогтоосон байна.
- Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/282 тоот захирамж, Захирамжийн хавсралтад газар эзэмших эрхийн гэрчилгээний талбайн хэмжээ өөрчлөх тухай тус цэцэрлэгийн 6376 м2 газрын хэмжээ нь 6990 м2 болж өссөн зөрүү 15.3 сая төгрөгийн газрыг орлого авах шийдвэрийн дагуу бүртгэлд авсан байна.
- Тайлант хугацаанд 43.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал зэрэг тус тус нөлөөлсөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 02 дугаар тогтоолоор тус цэцэрлэгийн төсвийг 746.2 сая төгрөгөөр баталж, тусгай зориулалтын шилжүүлгээс 652.9 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 93.2 сая төгрөгөөр батлагдсан байна.

Төсвийн жилийн явцад Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/281 тоот захирамжаар цалингийн зардал, хоолны зардалд 2.0 сая төгрөгийн зохицуулалт хийгдсэн.

Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн Төсөвт тодотгол хийх турай 01 тогтоолоор тус цэцэрлэгийн төсвийг 704.7 сая төгрөг буюу 41.5 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/608 дугаар захирамжаар 4.4 сая төгрөгийн зохицуулалт тус тус хийгдсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 617.4 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 94.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс тус тус санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 701.5 сая төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдсэн 9.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 701.5 сая төгрөг буюу 98.6 хувьтай байгаа нь ковид-19 цар тахлын улмаас 195 хоног хичээллэхээс 101 хоног хичээллэснээр нормативт зардал, байр ашиглалт, үндсэн цалинтай холбоотой тогтмол зардал дутуу зарцуулагдсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт төсвийн дансаар нийт 2.7 сая төгрөгийн орлогыг хүлээн авсан. Үүнд:

- Хөвсгөл аймгийн Боловсролын газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/40 тоот тушаалаар, сургалтын үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбоотой анги танхимын ариутгал халдваргүйжүүлэлт хийх зориулалтаар 0.3 сая төгрөгийн орлого авсан.
- Хөвсгөл аймгийн Засаг Даргын Тамгын Газраас ариутгалын зардалд 1.4 сая төгрөгийн орлого авсан.
- Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын тамгийн газраас постны хоолны зардалд 0.6 сая төгрөгийн орлого авсан.
- Цахим тендерийн орлого 0.3 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус авсан.

Нэмэлт төсвийн дансанд хүлээн авсан орлогын зарцуулалтын эрхийг Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн журамд заасан баримтын бүрдлийг ханган НТ№1 маягтаар төрийн санд хүргүүлж эрх нээлгэж зориулалтын дагуу ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж ажилласан байна. Үүнд:

- Байгууллагын эрхлэгчийн 2021 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн А/18 дугаар тушаалаар 0.3 сая төгрөгийг, цахим тендерийн бичиг баримтыг бэлтгэхтэй холбоотой бичиг хэргийн материал бэлтгэсэн байна.
- Байгууллагын эрхлэгчийн 2021 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/39 дүгээр тушаалаар 1.4 сая төгрөгийг сургалтын үйл ажиллагаа эхлүүлэхтэй холбоотой анги танхимын ариутгал халдваргүйжүүлэлт хийхэд зарцуулсан байна.
- Байгууллагын эрхлэгчийн 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/40 дүгээр тушаалаар 0.4 сая төгрөгийг сургалтын үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбоотой анги танхимын ариутгал халдваргүйжүүлэлтэд тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхдээ Монгол Улсын ерөнхий аудиторын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/111 дүгээр тушаалаар

баталсан санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу төсвийн хэмнэлтийн бодлого, зарцуулалт, шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилт, өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад асуудалд анхаарлаа хандуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн 10.2 саяаас доошгүй төгрөгийн хэмнэлтийг гаргаж ажиллахаас 54.5 сая төгрөгийг хэмнэж ажилласан байна.

3.8 Аудитын гол асуудал

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад АОУС 701.8-д тодорхойлсон үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд гараагүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын ерөнхий аудиторын “Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хэрэгжүүлэх ерөнхий чиглэл батлах тухай” 2021 оны А/108 дугаар тушаалаар батлагдсан чиглэлийн дагуу шилэн дансны мэээллийг шалгахад 1,198.0 сая төгрөгийн 88 мэдээллийг ил тод байршуулахаас, 1,178.6 сая төгрөгийн 86 мэдээллийг ил тод байршуулж, 19.4 сая төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож, мэдээлсэн байдлын хэрэгжилт 95 хувиар үнэлэгдэж байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Худалдан авах ажиллагааны тухайд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 42.2 сая төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс, 1.7 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 40.5 сая төгрөгийн 2 зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад санхүүгийн тайлагналтай холбоотой 1.7 сая төгрөгийн 1 алдааг залруулсан. Үүнд:

1. Нийгмийн даатгалын цахим системийн мэдээллийн дүнг, нягтлан бодох бүртгэлийн цалингийн зардал болон НДШ-ийн зардлын дүнтэй тулган шалгахад, цалингийн зардал 1.7 сая төгрөгийн зөрүүтэй буюу үндсэн цалингийн зардлыг 1.7 сая төгрөгөөр бууруулж тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4.үнэн зөв байх зарчим, 14.4.6.бүх зардал гэсэн заалтуудад нийцэхгүй байгаа тул аудитын хугацаанд залруулж ажилласан.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт өгөгдөөгүй болно.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй болно.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримт е-баримтаар бүрэн дэмжигдсэн эсэх

- 1.1 Илрүүлэлт: Мөнгөн хөрөнгийн зарлагын 21.0 сая төгрөгийн гүйлгээ нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13.1.4.доор дурдсан бараа, ажил, үйлчилгээний зардал Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх гэсэн заалтад нийцэхгүй байгаа нь "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 1.2 Өгсөн зөвлөмж: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13.1.4.доор дурдсан бараа, ажил, үйлчилгээний зардал Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

2. Шилэн дансны мэдээлэл

- 2.1 Илрүүлэлт Шилэн дансны мэдээллийг шалгахад 1,198.0 сая төгрөгийн 88 мэдээллийг ил тод байршуулахаас, 1,178.6 сая төгрөгийн 86 мэдээллийг байршуулж, 19.4 сая төгрөгийн 2 мэдээлэлийг хугацаа хоцроож мэдээлсэн байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 заалтад "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:" гэсэн заалтад нийцэхгүй нь "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 2.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 заалтад "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 7 дугаар цэцэрлэг	3	42.2	1	1.7	-	-	-	-	2	40.5

БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРААС

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР Огноо:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Э.БАТ-ЭРДЭНЭ Огноо:

АХЛАХ АУДИТОР

Г.ЭРДЭНЭЧИМЭГ Огноо:

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК

ХЯНАСАН: АУДИТОР

Ц.МӨНХТУЯА Огноо:

БОЛОВСРУУЛСАН: АУДИТОР

Б.МЯДАГМАА Огноо:

